



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХОЁРДУГААР ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ СОНГОХ СОНГУУЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу “МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХОЁРДУГААР ИХ ХУРАЛ”-ыг 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хуралдуулахаар товлосон.

Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Монголын Хуульчдын холбооны хоёрдугаар их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх ажиллагааг 2015 оны есдүгээр сарын 16-ны өдрийн 08:00 цагаас эхлүүлж, 2015 оны есдүгээр сарын 20-ны өдрийн 22:00 цагт дуусгахаар, их хурлын төлөөлөгчид нэр дэвшигчид санал өгөх ажиллагааг 2015 оны есдүгээр сарын 21-ний өдрийн 08:00 цагаас эхлүүлж, 2015 оны есдүгээр сарын 23-ны өдрийн 22:00 цагт дуусгахаар тус тус тогтоолоо.

Монголын Хуульчдын холбооны хоёрдугаар их хурлыг зохион байгуулах Ажлын хэсгийн 2015 оны есдүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдын төлөөллийн хэсэг тус бүрээр Хуульчдын холбооны хоёрдугаар их хурлын төлөөлөгч сонгох сонгуульд оролцох нийт 5042 хуульчийн нэрсийн жагсаалтыг баталгаажуулсан бөгөөд тус нэрсийн жагсаалтад өөрийн нэр бүртгэгдсэн эсэхийг www.mglbar.mn цахим хуудсанд байршуулсан “Их хурлын сонгуульд оролцох хуульчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгах зааварчилгаа”-ны дагуу шалгана уу.

Хэрэв хуульч та өөр төлөөллийн хэсэгт бүртгэгдсэн, эсхүл хувийн бүртгэл мэдээллийг алдаатай, буруу оруулсан бол их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс нэг хоногийн өмнө хүсэлтээ бичгээр эсхүл Хуульчдын холбооны цахим хуудас дахь “санал, гомдол” хэсгээр дамжуулан гаргаж, шийдвэрлүүлэх боломжтой.

Монголын Хуульчдын холбооны хоёрдугаар их хурлын төлөөлөгч сонгох, их хурлын зохион байгуулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг www.mglbar.mn цахим хуудсанд нэвтэрч авна уу. /Лавлах утас: 70116007, 70116995/

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО